



**2-р үе шатанд шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг  
бүрдүүлж ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яам,  
Россотрудничество агентлаг руу хүргүүлэх**

Сонгон шалгаруултанд амжилттай оролцсон горилогчид дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

1. Гадаад папортын хуулбар, орчуулга. \*Хүчинтэй байх хугаацаа нь Орос Улсад орсоноос хойш 18 сараас доошгүй байна.
2. Горилогчийн суралцах хүсэлт бүхий анкет, өнгөт зурагтай байна. Анкетыг [EDU.RS.GOV.RU](http://EDU.RS.GOV.RU) системд бүрдүүлсэн баримт бичгээс татаж авна.
3. Сонгосон мэргэжлийнхээ дагуу их дээд сургуулийн сонголтыг хийхдээ мэдээлийн <https://education-in-russia.com> систем дахь навигаторыг ашиглана уу.
4. Горилогч бүр 6 их дээд сургуулийн нэрийг сонгож болно. Гэхдээ холбооны нэг тойрогт гурваас дээшгүй, холбооны чанартай Москва, Санкт-Петербург хотоос тус бүр хоёроос дээшгүй сургууль заах эрхтэй.

Горилогчийн анкетанд заасан аль ч сургууль түүнийг суралцуулах сонголтыг хийгээгүй тохиолдолд Орос Улсын боловсролын яам горилогчид хандаж Москва, Санкт-Петербург хотоос бусад Орос Улсын дурын хот дахь их дээд сургуулийг сонгох тухай нэмэлт мэдүүлэг бичих санал тавина.

5. Боловсролын тухай баримт бичгийн эх хувь ба скан хуулбар, орчуулгын товчоор баталгаажулсан орчуулга (аттестат, бакалавр эсвэл магистрын диплом), сурлагын дүнг хавсралтаар ирүүлнэ.
6. Орос хэлний Зуны сургалтанд суралцах горилогч (орос хэлний багш, монголын их дээд сургуулиудын орос хэлний ахлах курсын оюутан)-ийн хувьд дээд боловсролын дипломын хуулбар, орчуулгын товчоор баталгаажулсан орчуулга, сургууль, ажлын газрын тодорхойлолт; поликлиникийн тамга бүхий эмнэлэгийн дүгнэлт ( У-086 маягт), ХДОХВ, гепатит, сүрьеэ өвчингүй болохыг нотолсон эмнэлэгийн магадлал.
7. Сургуулийн төгсөгчийн хувьд сүүлчийн аттестатчлалын дүн 11-р анги (11 жилийн сургалттай бол) эсвэл 12-р ангийн эхний хагас жилийн дүн (12 жилийн сургалттай бол).
8. 1-2-р курсын оюутнуудын хувьд сургалтын хэлтсийн тамга бүхий сурлагын тухай тодорхойлолт ( дундаж оноо 2,8-аас доошгүй буюу “сайн”), бүрэн дунд боловсролын аттестат.



9. Гэрээний дагуу оросын их дээд сургуулийн бэлтгэл ангид суралцагчдын хувьд- оросын их дээд сургуулийн бэлтгэл ангид гэрээгээр суралцагсадын хувьд 1-р семестрийн орос хэл, чиглэлийн (сургалтын чиглэлээр: хүмүүнлэгийн, техникийн, анагаах ухааны, эдийн засгийн гэх мэт), хичээлийн сурлагын тодорхойлолт, бүрэн дунд боловсролын тухай аттестатын хуулбар;
10. Аспирантурын хөтөлбөрөөр суралцах горилогчдын хувьд: нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсалт эсвэл суралцах чиглэлд тохирсон сэдэв бүхий реферат (10-аас доошгүй хуудастай байх )
11. Улсын эмнэлэгийн тамга бүхий эмнэлэгийн тодорхойлолт ( У-086 маягт)
12. ДОХ-оор өвчлөөгүй болохыг нотолсон эмнэлэгийн магадлал.

### **БҮХ БАРИМТ БИЧГИЙГ ОРОС ХЭЛЭНД ХӨРВҮҮЛЖ ОРЧУУЛГЫН ТОВЧООНЫ ТАМГАР БАТАЛГААЖУУЛСАН БАЙХ ЁСТОЙ**

**ЧУХАЛ:** Тогтоосон хугацаанд баримт бичгээ бүрдүүлж чадаагүй горилогчийг ОХУ-ын Засгийн газрын тэтгэлэгээр суралцах эрх бүхий горилогчдын нэрийн жагсаалтаас хасна.